


БАТЛАВ: БМИҮЗ-ИЙН АЖЛЫН АЛБАНЫ ЗАХИРАЛ  О.ЯНЖМАА

**“БҮТЭЭЛЧ ОЮУТАН-2020” ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ**

**Зохион байгуулагч:** Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл

**Хамрах хүрээ:** Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн нийт оюутнууд

**Зорилго:** Боловсролын чанарыг сайжруулахад хувь нэмрээ оруулж буй суралцахуйн шилдэг туршлагыг шалгаруулж, дэмжин сурталчилж, түгээн дэлгэрүүлж, урамшуулах.

**Хүрэх үр дүн:** БМИҮЗ-ийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалт, судалгаа, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулахад суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх, оюутнууд харилцан бие биенээсээ суралцах, суралцахуйн шилдэг арга барил, туршлагаа хуваалцах боломжийг бүрдүүлэх.

**Ач холбогдол:** Жил бүр уламжлал болгон зохион байгуулснаар оюутан суралцагчид суралцахуйн үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт өгөх, шилдэг сайн туршлагаас суралцах, суралцахуйн арга барилаа сайжруулах, шинийг эрэлхийлэх, бүтээлч байдлаа нэмэгдүүлэх, судалгаа шинжилгээ хийх, нийгмийн идэвхтэй байх, тасралтгүй хөгжих, чадавхжих, амжилтад хүрэх эрмэлзлийг нэмэгдүүлэх.

**Зохион байгуулалт:**

- Шалгаруулалтад оролцох Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн оюутнууд тодорхой амжилт, үр дүнд хүрсэн, баримтад тулгуурласан, өөрийн бүтээлч үйл ажиллагааны тайлан илтгэлээ /цаашид “илтгэл” гэнэ/- үндсэн 3 шалгуур үзүүлэлтийн дагуу бичиж холбогдох баримт материалын хамт шалгаруулах комисст ирүүлнэ.
- Оролцогчдын нэр, хаяг илтгэлд бичигдэхгүй, зөвхөн өргөдөлд бичигдэнэ.
- “Бүтээлч оюутан-2020” шалгаруулах үйл ажиллагаа нь 2 үе шаттай явагдана.
  - 1-р үе шат: Оролцогчдоос ирүүлсэн илтгэл, холбогдох материалыг Комисс нягтлан уншиж танилцан дараагийн шатанд хэлэлцэх илтгэлийг сонгоно.
  - 2-р үе шат: 1-р шатнаас шалгарсан оюутнууд илтгэл тавьж хэлэлцүүлнэ.
- Комиссын гишүүн бүр ирүүлсэн илтгэл, материалыг шалгуур үзүүлэлт бүрээр дүгнэнэ.
- Оюутнуудын илтгэлд Комиссын гишүүн бүр 100 хүртэлх оноог өгөх бөгөөд онооны дунджаар илтгэлийн оноо гарна.

**Илтгэл хүлээн авах, шалгаруулах:**

№	Үйл ажиллагаа	Хаана	Хугацаа
1	Оюутнуудын илтгэл, танилцуулга /PPT/-г хүлээн авах	Комиссын нарийн бичиг БМИҮЗ ажлын алба №401	2020.10.15-2020.10.28
2	Нэгдүгээр шатны шалгаруулалт	Комисс.	2020.11.02-2020.11.04
3	Хоёрдугаар шатны шалгаруулалт	Комиссын нарийн бичиг	2020.11.09-2020.11.13

		БМИҮЗ Ажлын алба №401	
4	Хоёрдугаар шатны шалгаруулалт	Багшийн хөгжлийн ордон №202	2020.11.18

### Шалгаруулах комисс:

- Хоёр шатны шалгаруулалтыг БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн, шинжээч-их, дээд сургуулийн багш, шинжээч-оюутны бүрэлдэхүүнээс оролцуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй Комисс шалгаруулна.
- Комиссын бүрэлдэхүүнийг Ажлын албаны захирлын тушаалаар батална.

### Шагнал урамшуулал

Бүтээлчээр суралцахуйн шинэлэг арга барил, туршлагаа хуваалцах, түгээн дэлгэрүүлэхүйц гурван илтгэлийг шалгаруулна. Үүнд:

- Нэгдүгээр байр: “Бүтээлч оюутан-2020” өргөмжлөл, цом, 1.000.000 төгрөгийн мөнгөн шагнал, БМИҮЗ-ийн Шинжээч оюутнаар ажиллах эрх
- Хоёрдугаар байр: “Бүтээлч оюутан-2020” өргөмжлөл, 500.000 төгрөгийн мөнгөн шагнал, БМИҮЗ-ийн Шинжээч оюутнаар ажиллах эрх
- Гуравдугаар байр: “Бүтээлч оюутан-2020” өргөмжлөл, 300.000 төгрөгийн мөнгөн шагнал, БМИҮЗ-ийн Шинжээч оюутнаар ажиллах эрх

### Суралцахуйн шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх тухай

- Хоёрдугаар шатны шалгаруулалт явагдах хурлын өмнө илтгэлийн хураангуй хэвлэгдэнэ.
- Хурлын дараа бичвэр ба илтгэлд тавигдах шаардлага хангасан илтгэлүүдээр илтгэлийн эмхтгэл гаргаж, цахим сүлжээнд байршуулна.
- Бүтээлчээр суралцахуйн шинэлэг арга барил, туршлага хуваалцах, түгээн дэлгэрүүлэхүйц илтгэлийг БСШУСЯ, БМИҮЗ-ийн вэб сайтад байршуулж, нийгмийн сүлжээгээр сурталчилж, олон нийтэд түгээнэ.

### “Бүтээлч оюутан-2020” шалгаруулах шалгуур үзүүлэлт

1. Суралцахуйн хөгжилд 50 оноо
  - 10 оноо. Суралцаж буй мэргэжлийн хөгжилд өөрийн оруулах хувь нэмрийг хэрхэн тооцоолж баталгаажуулдаг байдал
  - 10 оноо. Судалж буй хичээл бүрээр амжилттай суралцах төлөвлөгөөг хэрхэн гаргаж, хэрэгжүүлдэг байдал
  - 10 оноо. Тухайн сэдвийн талаар шинэ мэдлэгийг хэрхэн бий болгож бүтээлчээр суралцдаг байдал
  - 10 оноо. Салбарын ирээдүйн хөгжлийн чиг хандлага, бодлогын талаар үргэлж анхаарч, суралцах үйл явцтайгаа хэрхэн уялдуулдаг байдал
  - 10 оноо. Сурлагын амжилтаа хэрхэн тасралтгүй дээшлүүлсэн байдал
2. Судалгаа, мэргэжлийн хөгжилд 20 оноо
  - 10 оноо. Судалгааны баг, төсөл, хөтөлбөрт оролцож үзүүлсэн амжилт

- 10 оноо. Судалгааны үр дүнг хэрэгжүүлсэн, шинэ бүтээл бий болгосон, туршлага
3. Нийгмийн идэвх 30 оноо
- 10 оноо. Сургалтын үйл ажиллагаанаас гадна мэргэжлийн чиглэлийн уралдаан тэмцээн, эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцож амжилт үзүүлсэн туршлага
  - 10 оноо. Суралцаж буй чиглэлийн хөтөлбөрийн хөгжилд оруулж буй хувь нэмэр, оролцоо, санал санаачилга
  - 10 оноо. Нийгэм, олон нийтийн төрөл бүрийн үйл ажиллагаанд үр дүнтэй оролцдог байдал

**Бүрдүүлэх материал:**

- Өргөдөл /маягтаар/
- Оюутны суралцсан хугацааны үнэлгээний баталгаажуулсан тодорхойлолт
- Оюутны нийгмийн идэвх болон өөрийн амжилтыг баталгаажуулсан баримт материал
- Өөрийн бүтээлч үйл ажиллагааг 1500 үгэнд багтаан бичсэн илтгэл
- Илтгэлийн PPT материал

**Холбоо барих: Улаанбаатар хот, Энхтайвны өргөн чөлөө-10, Багшийн хөгжлийн ордон 401 тоот. Утас: 70109391. И-мэйл: info@accmon.mn**

**БМИҮЗ-ийн АЖЛЫН АЛБА**

“БҮТЭЭЛЧ ОЮУТАН-2020” ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ ӨРГӨДӨЛ

Овог:

Нэр:

Регистрийн дугаар:

Утасны дугаар:

И-мэйл хаяг:

Оршин суух хаяг:

Сургуулийн нэр:

Хөтөлбөрийн нэр:

Курс:

Суралцсан хугацааны голч дүн:

Шагнал, урамшуулал:

Сонгуульт ажил:

Зураг 3x4

Дараах үйл ажиллагаанд оролцсон бол товч бичнэ үү!

- Эрдэм шинжилгээний хурал:
- Мэргэжлийн уралдаан, тэмцээн, олимпиад:
- Судалгааны баг, төсөл, хөтөлбөр:
- Нийгэм, олон нийтийн ажил:

Өргөдөл гаргасан:

/гарын үсэг/ Огноо:

Комиссын нарийн бичиг бөглөх

Өргөдөл хүлээн авсан огноо: .....

Оюутанд өгсөн код: .....